

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

Тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 10 дугаар зүйлд заасан нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээ болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг хоёр сая төгрөг /2 000 000/-өөр тогтоосугай.

2.Амьгүй донор болж эс, эд, эрхтэнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг гурван сая таван зуун мянган төгрөг /3 500 000/-өөр тогтоосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба (Г.Банзрагч)-нд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн “Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Гарын үсэг